

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ИХ СУНГАА НИЙГМИЙН УХААН Хувилбар В

1. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Тухайн үйлдлийг гүйцэтгэгчээс мэдэж тооцоолсон үр дагаврыг нийгмийн институтын гэнэ.

- A. Үүргийн зөрчил B. Далд чиг үүрэг C. Сөрөг чиг үүрэг
D. Ил чиг үүрэг E. Үүрэг

2. “Бидний үед сумын төвд зурагт гэж байсангүй тул Монголын радиогийн уран зохиол, яруу найргийн нэвтрүүлгийг чих тавин сонсдог байсан” гэсэн өгөгдөл нь нийгэмшилтийн аль агентад хамаарах вэ? /1 оноо/

- A. Үе тэнгийнхэн B. Сургууль C. Хэвлэл мэдээлэл
D. Гэр бүл E. Ажлын байр

3. Эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн бүтэц, соёлоос хамааран тодорхойлогдох ялгаа, нийгмийн харилцааны явцад бүтээгддэг, хүнд төлөвшдөг шинжийг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Хүйс B. Жөндөр C. Насны нийтлэг /1 оноо/
D. Угсаатны нийтлэг E. Тэгш бус байдал

4. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг гэнэ.

- A. Бэлгэ тэмдэг B. Хэл C. Мэдлэг D. Үнэлэмж E. Хэм хэмжээ

5. Соёлыг хүй нэгдлийн, эртний, дундад зууны, сэргэн мандалтын, шинэ үеийн, орчин үеийн гэж ангилсан нь соёлын аль шалгуур үзүүлэлтэд хамаарч байна вэ? /1 оноо/

- A. Түүхэн хэв маягаар нь B. Аж ахуй эрхлэлтээр нь
C. Бүтээгч, хэрэглэгчээр нь D. Суурь үнэлэмжээр нь
E. Сонголт хийх боломжоор нь

6. Археологи, архитектур, гар урлал, үндэсний тоглоом, хувцас загвар, кино, дүрслэх урлаг, зар сурталчилгаа зэрэг нь соёлын аль ойлголтод хамаарах вэ? /1 оноо/

- A. Соёлын эрх чөлөө B. Соёлын даяаршил C. Соёлын орон зай
D. Соёлын дархлаа E. Соёлын үйлдвэрлэл

7. Дараах байгууллагуудын аль нь соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэн явуулдаг вэ? /1 оноо/

- A. “Сүү” ХХК B. Эмнэлэг C. Цагдаагийн байгууллага
D. Музей, галерей E. Улаан загалмайн нийгэмлэг

8. Нийгэмшилтийн талаарх ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

/3 оноо/

a	Сургууль	1	Итгэж байсан зүйлээсээ ухарч, хатуу ширүүн дэг журамд зохицон, өөрийгөө хүлээн авах дүр зургаа өөрчлөх гарцаагүй нөхцөлд ордог.
b	Дахин нийгэмшилт	2	Нийгэмшилтийн явцад хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг, нийгэмд харьяалуулан, тэдгээрийг илэрхийлэгч онцлог шинжийг тээгч нь болдог.
c	Адилсал	3	Тодорхой зорилго, түүнд хүрэх арга хэрэгсэл агуулга бүхий албан ёсны хөтөлбөрөөр хүүхдийн нийгэмшилтэд хувь нэмэр оруулахаар зорьж ажилладаг.

- A. a2,b1,c3 B. a1,b2,c3 C. a3,b1,c2 D. a2,b3,c1 E. a1,b3,c2

9. Бусад хувьсагчийн нөлөөгөөр өөрчлөгдөж буй хувьсагчийг хамаарах хувьсагч гэнэ. Жишээ нь: Ажилгүйдлийн түвшин өсөхөд ДНБ-ний хэмжээ буурдаг гэсэн өгөгдлөөс хамаарах хувьсагчийг олно уу. /1 оноо/

- A. Инфляци B. ДНБ-ний хэмжээ C. Ажил эрхлэлт
D. Ажилгүйдэл E. Ажилгүйдлийн түвшин

10. Багш Чимгээгийн 2019-2020 оны хичээлийн жилд ангийн сурагчдын төлөвшлийг судалсан ажиглалтын судалгааны үр дүнгээс харахад сурагчдын зан төлөв, идэвх оролцоо, харилцаа хандлага зэрэг нь мэдэгдэхүйц сайжирсан байгаа нь харагдаж байна. Судалгааны аргыг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Туршилт B. Тоон судалгаа C. Бүлгийн ярилцлага
D. Чанарын судалгаа E. Контент анализ

11. Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүний эрх мэдэлд хамаарах ойлголтыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Үе залгамжилсан уламжлалт нэр хүнд
B. Ажил мэргэжлийн нэр хүндийн үнэлгээ
C. Онцгой авьяас чадвар
D. Олонд танигдсан байдал
E. Шийдвэр гаргах, шийдвэрт оролцох

12. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Олон нийтийн хөдөлгөөнд тулгуурласан, өргөн хүрээтэй шинэчлэл буюу засаглалын бүтэц, дэглэмийг өөрчлөхөд хүргэдэг, хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлсэн үйлдлийг гэнэ.

- A. Хувьсгал B. Хувьсал C. Нийгмийн хөдөлгөөн
D. Шинэчлэл E. Нийгмийн өөрчлөлт


13. Германы социологич Ф.Теннисын нийгмийн хэв маягийн ангиллаас Гезеллшафт /хотын буюу орчин үеийн/-ын онцлог шинжийг олно уу. /1 оноо/

- A. Хөдөлмөрийн хуваарь энгийн B. Уламжлал ёс, зан заншил
C. Нийгэм, хамт олны зарчим үйлчилдэг D. Хөдөлмөрийн хуваарь нарийссан
E. Шашин, сүсэг бишрэл онцгой үүрэгтэй

14. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг зэрэг шинжүүдээр шууд ялгаагүй ч ямар нэг стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь ялгаатай байдалд хүргэхийг гэнэ.

A. Институтийн алагчлал B. Шууд алагчлал C. Шууд бус алагчлал
D. Бурангуй үзэл E. Алагчлал

15. Монголын түүхэн үеүд дэх нийгмийн давхраажилтыг харуулсан зураглалаас орхигдсон хэсгийг нөхөж бичнэ үү. /3 оноо/



A. 1. XII-XIV зууны үе, 2. Талын язгууртнууд
B. 1. Манжийн эрхшээлийн үе, 2. Сэхээтэн
C. 1. Манжийн эрхшээлийн үе, 2. Хөх захтан
D. 1. XII-XIV зууны үе, 2. Сэхээтэн
E. 1. Их Монгол Улсын үе, 2. Хамжлага ард

16. Нийгмийн нийтлэгүүдийг зөв харгалзуулна уу. /3 оноо/

a	Үндэс угсаа, хэл, соёл, түүх, зан заншил, газар нутаг, шашин зэргээр ижил төстэй нийгмийн нийтлэг	1	Насны нийтлэг
b	Хүний физиологийн хөгжлийн утгыг илэрхийлэхээс гадна нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлдог нийтлэг	2	Угсаатны нийтлэг
c	Зонхилгоч биш шашныхан алагчлалд өртөн, улмаар олонхтой харьцуулахад харьцангуй дорой нөхцөлд аж төрөх нь бий	3	Шашны нийтлэг

A. a3,b1,c2 B. a3,b2,c1 C. a2,b3,c1 D. a2,b1,c3 E. a1,b2,c3

17. "Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн /хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт/ нэгдэл мөн" гэж тодорхойлсон судлаачийг нэрлэнэ үү. /1 оноо/

A. К.Ясперс B. А.Гидденс C. Р.Бенедикт D. Э.Тайлор E. Э.Кассирер

18. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг холбогдох ойлголттой нь **буруу** илэрхийлсэн хариулт аль нь вэ? /2 оноо/

A. Мэдлэг- шинжлэх ухаан, хууль B. Хэл- дохио зангаа, хөдөлгөөн
C. Бэлгэ тэмдэг- төрийн дуулал, гэрлэн дохио D. Үнэлэмж- хүний эрх, шударга ёс
E. Хэм хэмжээ- дүрэм, журам, ёс заншил

19. Харилцааны явцад харилцагч ямар үүргийг гүйцэтгэх тухай бэлгэ тэмдэг хувь хүнд төлөвшиж байдаг. Жишээ нь: Ээжтэйгээ харилцах явцад ээжийн үүргийн талаарх хувийн төсөөлөл бүрэлдэн тогтож, бүх ээжүүдээс энэ төсөөллийнхөө дагуу тодорхой зан үйлийг хүлээж байдаг ажээ. Дараах онолуудын алийг нь илэрхийлж байна вэ? /2 оноо/


A. Марксийн B. Бүтэц чиг үүргийн C. Иргэншлийн
D. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн E. Шалтгаант чанарын

20. Монгол улсын хэмжээнд 1995 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр "Мөнх тэнгэрийн бичиг" уран бичлэгийн уралдаан зохион байгуулж ирсэн. Энэ нь олон улсын хэмжээн дэх соёлын бодлогын аль чиглэлд хамаарч байна вэ? /2 оноо/

A. Соёлын зорилго, хөгжлийн хандлагыг хүний хөгжилд чиглүүлэх
B. Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог хангах
C. Үндэсний хэлний цэвэр ариун байдлыг сахин хамгаалах
D. Үндэстэн, ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах
E. Соёлын харилцааг нээлттэй байлгах

21. Соёлын ойлголтуудын холбоо хамаарал, агуулгын багтаамжийг зөв илэрхийлсэн бүүдүүч аль нь вэ? /2 оноо/

a. соёл б. нэг хэв загварын соёл в. социализмын үеийн Монголын нийгмийн соёл



22. Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдолд хамааралтайг нь ялгана уу. /2 оноо/

1. Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгох
2. ДНБ-ны хэмжээг нэмэгдүүлж, амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг
3. Нийгмийн шударга ёсны зарчим, үнэ цэнийг бууруулдаг
4. Дэлхий нийтэд өөрсдийн брэндийг бий болгох

A. 1,3,4 B. 1,2,3,4 C. 1,2,4 D. 2,3,4 E. 1,2,3

23. Хүмүүсийг соёлын өвөрмөц хэв шинжээс нь болж нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд оролцох боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхах, хавчих зэрэг нь соёлын эрх чөлөөг зөрчих хандлагын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Соёлын эрх чөлөө
- B. Хүний эрх, эрх чөлөө
- C. Тэгш эрх, шударга ёс
- D. Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
- E. Амьдралын хэв маягийг үгүйсгэх

24. Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлын дадал хэвшлээсээ хавьгүй илүүд үзэж хүлээн зөвшөөрсөн сэтгэлгээний үр дүн нь соёлын харилцан үйлчлэлийн аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Соёлын дархлаа
- B. Соёлын солилцоо
- C. Соёлын тулгалт
- D. Соёлын даяаршил
- E. Соёлыг хуулбарлан дуурайх

25. Соёлын даяаршлын **сөрөг** үр дагаваруудыг нэрлэнэ үү. /2 оноо/

1. Өөрийн соёлын уламжлалт хэв маягаас татгалзах
2. Үндэсний аюулгүй байдал алдагдах, дархлаа сулрах
3. Байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдах
4. Олон ургалч соёл дэлгэрч, янз бүрийн соёлыг мэдрэх боломж

A. 1,3,4 B. 1,2,3,4 C. 1,2,4 D. 1,2,3 E. 2,3,4

26. Хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бэлэн байгаа төрөл бүрийн мэргэжилтэй ажиллах хүчний тоог юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Тэнцвэрт байдал
- B. Хөдөлмөрийн эрэлт
- C. Хөдөлмөрийн нийлүүлэлт
- D. Ажиллах хүч
- E. Хөдөлмөрийн зах зээл

27. Ажиллах хүчний эрэлт нь нийлүүлэлтээс давсан /Э>Н/ үед хөдөлмөрийн зах зээл дээр үүсэх үр дагавар аль нь вэ? /2 оноо/

- A. Ажиллах хүчний илүүдэл үүснэ
- B. Ажиллах хүчний хомсдол үүснэ
- C. Тэнцвэрт байдал бий болно
- D. Хөдөлмөрийн бүтээмж өснө
- E. Байгууллагын зардал буурна

28. Арилжааны банкны онцлог шинж аль нь вэ? /1 оноо/

- A. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх
- B. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
- C. Зээл олгох, төлбөр тооцоо хийх
- D. Валютын улсын нөөцийг эзэмших
- E. Арилжааны банкуудыг хянах

29. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/

Нэрлэсэн цалинг инфляцийн түвшинд харьцуулж тооцдог, хүн амын амьжиргааны түвшинг хэмждэг үзүүлэлтийг гэнэ.

- A. Нэрлэсэн цалин
- B. Бодит цалин
- C. Шагнал урамшуулал
- D. Үндсэн цалин
- E. Нэмэгдэл хөлс

30. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Хятад улсын хөрөнгө оруулалттай компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг аль улсын ДНБ, ҮНБ болохыг ялгана уу. /2 оноо/

- A. Хятад улсын ДНБ, Монгол улсын ДНБ
- B. Монгол улсын ҮНБ, Хятад улсын ДНБ
- C. Хятад улсын ҮНБ, Монгол улсын ҮНБ
- D. Монгол улсын ДНБ, Хятад улсын ҮНБ
- E. Монгол улсын бодит ҮЦБ, Хятад улсын ҮЦБ

31. ДНБ-ий орлого болон зардлыг ялгаж, тооцоолол хийнэ үү. /3 оноо/

№	ДНБ-ны бүтэц	Млрд төгрөгөөр
1	Төрийн зардал	90
2	Аж ахуйн нэгжийн зардал	130
3	Цалин	230
4	Зээлийн хүү	30
5	Шууд бус татвар	25
6	Өрх гэрийн хэрэглээний зардал	280
7	Түрээс	20
8	Гадаадын хэрэглэгчдийн зардал	60

- A. орлого- 255, зардал- 525
- B. орлого- 560, зардал- 305
- C. орлого- 285, зардал- 580
- D. орлого- 580, зардал- 285
- E. орлого- 305, зардал- 560

32. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/

Үнэт цаас гаргах, бүртгүүлэх, арилжих, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцааг гэнэ.

- A. Санхүүгийн зах зээл
- B. Бараа, үйлчилгээний зах зээл
- C. Хөдөлмөрийн зах зээл
- D. Зах зээлийн харилцаа
- E. Эдийн засгийн харилцаа

33. Үнэт цаас худалдан авагчдын төрөл болон шинжийг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /3 оноо/

1. Өрсөлдөгчид
2. Наймаачид
3. Ердийн хүмүүс

- a. (_) Өөрсдийн хуримтлалыг ногдол ашгаар арвижуулахыг хүссэн хүмүүс
- b. (_) Хувьцааг худалдах-худалдан авах замаар ашиг олох зорилготой хүмүүс
- c. (_) Тухайн нэг компанийг өөрийн эрхшээлд оруулахын тулд түүний хувьцааг худалдан авахыг хүссэн хүмүүс
- A. a2,b3,c1 B. a3,b1,c2 C. a1,b2,c3 D. a3,b2,c1 E. a1,b3,c2

34. Гүйлгээнд их хэмжээний мөнгө бий болж, харин түүгээр худалдан авах барааны тоо хэмжээ бага байгаагаас барааны үнэ өсөхөд хүргэдэг нь инфляци үүсэх шалтгааны аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Мөлхөө инфляци B. Зардлын инфляци C. Эрэлтийн инфляци
D. Хэвийн инфляци E. Гипер инфляци

35. Ажилгүйдлийн түвшин 3 хувь өссөн үед бий болох эдийн засгийн үр дагаварыг Оуэкену хуулиар тооцоолон гаргана уу. /2 оноо/

- A. ДНБ 2,5%-иар буурна B. ДНБ 7,5%-иар буурна C. ДНБ 7,5%-иар өснө
D. ДНБ 2,5%-иар өснө E. ДНБ 3%-иар буурна

36. Зөвлөлдөх санал асуулгад оролцож хуулийн төсөлд саналаа өгөх нь иргэдийн оролцооны аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. ИТХ болон ИНХ-д оролцох
B. Төлөөллөөр дамжуулан оролцох
C. Улс төрийн сонгуульд оролцож саналаа өгөх
D. Хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох
E. Сонирхлын бүлгээр дамжуулж оролцох

37. Дараах ойлголтуудаас иргэдийн **нийцгүй** оролцоог ялгана уу. /2 оноо/

1. Өлсгөлөн зарлах
2. Эсэргүүцлийн жагсаал цуглаан
3. Сонгуульд оролцож саналаа өгөх
4. Захидал бичих
5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан үзэл бодлоо илэрхийлэх
6. Авлига өгөх

- A. 2,3,6 B. 1,4,6 C. 1,2,3,4 D. 1,2,5,6 E. 1,2,6

38. "Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл явдал юм" гэж хэлсэн эрдэмтэн аль нь вэ? /1 оноо/

- A. Д.Истон B. Н.Макиавелли C. Р.Даль D. Ж.Локк E. А.Линкольн

39. Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх нь ардчиллын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Элитийн ардчилал B. Шууд ардчилал
C. Олон ургалч ардчилал D. Төлөөллийн ардчилал E. Ардчилал

40. Монгол улсын Үндсэн хуульд "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж заасан нь ардчиллын аль үнэт зүйлстэй нийцэж байна вэ? /1 оноо/

- A. Иргэдийн улс төрийн оролцоо B. Хүний эрх, эрх чөлөө C. Тэгш эрх
D. Олон намын тогтолцоо E. Хуулийн засаглал

41. Иргэд Засгийн газарт санал өгөх боломжуудыг нэрлэхдээ **буруу** зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Иргэд Засгийн газарт хандаж саналаа захидлаар илэрхийлэх
B. Засгийн газрын хуралд оролцож шийдвэр гаргах
C. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд саналаа өгөх
D. Орон нутгийн төр захиргааны байгуулагадаа хандаж саналаа өгөх
E. Засгийн газрын мэдээллийн вэб сайтад хандаж саналаа өгөх

42. Эрх зүйн актуудын төрөл болон төрийн байгууллагыг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /2 оноо/

1. Тогтоол 2. Тушаал 3. Зарлиг

- a. () Монгол Улсын Ерөнхий сайд
b. () Монгол Улсын Засгийн газар
c. () Монгол Улсын Ерөнхийлөгч

- A. a3,b2,c1 B. a2,b3,c1 C. a3,b1,c2 D. a2,b1,c3 E. a1,b2,c3

43. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн харилцааг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас бичгээр захирамжилсан шийдвэрийг гэнэ.

- A. Тогтоол B. Хууль C. Зарлиг D. Тушаал E. Хуульчилсан акт

44. Аав, ээж нь гэрээсээ хол, илүү цагаар ажилладаг тул гурван хүүхэд нь гэртээ хоол унд муутай, даарсны улмаас өвчин тусжээ. Энэ тохиолдолд Хүүхдийн эрхийн Конвенцийн дараах заалтуудаас аль нь зөрчигдөж байна вэ? /2 оноо/

- A. Эцэг эх нь хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэхгүй байх;
B. Хүүхдийн захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн халдаж болохгүй;
C. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;
D. Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, сүсэглэх эрхийг хүндэтгэх;
E. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх;

45. Монгол улсын иргэний журамт үүрэг аль нь вэ? /1 оноо/

- A. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
- B. Хуулиар ногдуулсан албан татвар төлөх
- C. Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх
- D. Байгаль орчноо хамгаалах
- E. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах

46. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг” гэж заасан нь хүний эрхийн аль суурь зарчим бэ? /1 оноо/

- A. Хүн үнэ цэн, нэр төртэй байх
- B. Түгээмэл, салшгүй байх
- C. Хуваагдашгүй байх
- D. Харилцан хамааралтай байх
- E. Хариуцлага тооцох

47. Анх боолуудыг чөлөөлж, бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг тунхаглан, хүний эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай түүхэн баримт аль нь вэ? /1 оноо/

- A. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- B. Сирусын бортого
- C. Эрх чөлөөний харти
- D. Үндсэн хууль
- E. Конвенц

48. Хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдээс **илүүц** зүйл оруулсан бол аль нь вэ? /2 оноо/

- A. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ
- B. Ажлын байрны буюу албан тушаалын нэр
- C. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг
- D. Нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал
- E. Хөдөлмөрийн нөхцөл

49. Хүн амын тодорхой хэсэг болж буй бусдаас дэмжлэг, туслалцаа шаардаж байгаа ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эх /эцэг/ болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий арга хэмжээг нийгмийн хамгааллын эрх зүйн аль харилцаагаар зохицуулдаг вэ? /1 оноо/

- A. Нийгмийн хамгааллын эрх зүй
- B. Нийгмийн даатгал
- C. Иргэний эрх зүй
- D. Захиргааны эрх зүй
- E. Нийгмийн халамж

50. Иргэн - Захиргааны байгууллагатай харилцахдаа эдлэх эрхийг олно уу. /1 оноо/

- A. Мэдэх эрх
- B. Захиргааны шийдвэр, үйл ажиллагаа
- C. Өргөдлийг шийдвэрлэх үүрэг
- D. Гомдлыг шийдвэрлэх үүрэг
- E. Хүссэн мэдээллийг өгөх үүрэг

51. Монгол улс үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулах нь Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчмын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Үндэсний эрх ашигт нийцсэн
- B. Прагматик /идэвхтэй/
- C. Тэнцвэртэй
- D. Олон тулгууртай
- E. Хамтын ажиллагаа

52. Олон улсын харилцааны үндсэн оролцогчийг олно уу. /1 оноо/

- A. Дэлхийн зөн олон улсын байгууллага
- B. Билл Гейтс
- C. Унгар улс
- D. Тоёото корпораци
- E. Олон улсын шүүх

53. Монгол улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчинг бүрдүүлэх нь Монгол улсын гадаад харилцааны аль бодлогын зорилго вэ? /1 оноо/

- A. Хүмүүнлэгийн
- B. Эдийн засгийн
- C. Соёлын
- D. Улс төрийн
- E. Шинжлэх ухааны

54. Олон улсын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр үүсгэн байгуулагдаагүй, ашгийн бус, хоёроос дээш улсаас хандив авч үйл ажиллагаа явуулдаг олон улсын харилцааны улс бус оролцогч аль нь вэ? /1 оноо/

- A. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ
- B. Үндэстэн дамнасан корпораци
- C. Олон улсын байгууллага
- D. Нөлөө бүхий хувь хүн
- E. Олон улсын төрийн бус байгууллага

55. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ уу. /1 оноо/ Монгол улсын хоёр хөрштэйгээ харилцдаг дараах чиглэлүүдээс орхигдсон хэсгийг олно уу.

- Улс төрийн
-
- Боловсролын
- Хүмүүнлэгийн
- Соёлын

- A. Эдийн засгийн
- B. Сайн хөршийн
- C. Тэнцвэртэй
- D. Хамтын ажиллагааны
- E. Олон тулгуурт

56. Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго аль нь вэ? /1 оноо/

- A. Шинжлэх ухаан, технологийн чадавхийг нэмэгдүүлэх
- B. Түүх соёлын үнэт зүйлээ сэргээн хамгаалах
- C. Дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх
- D. Эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах
- E. Гадаад сурталчилгааг сайжруулах

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1 Олон улсын харилцааны улс бус оролцогчдыг нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Нөлөө бүхий хувь хүн	1	Хувийн, сайн дурын үндсэн дээр бий болсон, нийгэм, хүмүүнлэгийн асуудлуудад байнга анхаарч ажилладаг, үүрэг даалгаварт чиглэсэн олон нийтийн байгууллага
b	Олон улсын төрийн бус байгууллага	2	Дэлхийд түгээмэл тархсан буддын шашин, ислам, христын гэх мэт голлох шашны бүлгүүд олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг.
c	Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3	Хоёр ба түүнээс дээш оронд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг, ажлын байр нь байдаг, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллага
d	Шашны бүлгүүд	4	Өдгөө цахим мэдээллийн хэрэгслүүд, олон улсын хэвлэл мэдээллийн төрөлжсөн байгууллагууд, сонин, зурагтын сүлжээ зэрэг нь олон улсын улс бус оролцогчдын нэг чухал төлөөлөл болсон.
e	Үндэстэн дамнасан корпораци	5	Орчин үед олон улсын харилцаанд Засгийн газрыг төлөөлөхгүй нөлөө бүхий хүмүүсийн үүрэг, оролцоо чухал болсон.

2.2 Бүдүүвчид ардчиллын үнэт зүйлсийг (a-e) харуулжээ. Эдгээрийг тохирох утгатай нь (1-5) зөв тохируулна уу. /5 оноо/



1. Хүний эрх нь нийгмийн харилцаанд оролцох боломжийн хэм хэмжээг илэрхийлсэн ойлголт.
2. Иргэд төрийн хэрэгт оролцох нь тэдний эрх төдийгүй иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг юм.
3. Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэгтэй.
4. Иргэн бүр хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээдэг.
5. Ардчилсан нийгэмд иргэдийг боловсролтой болоход анхаардаг бөгөөд боловсролтой иргэд нь ардчиллыг хөгжүүлэх нэг гол хөшүүрэг гэж үздэг.

2.3 Соёлын чиг үүргүүдийг зөв харгалзуулна уу.

/5 оноо/

a	Бэлгэдлийн чиг үүрэг	1	Соёл нь нийтлэг итгэл үнэмшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг.
b	Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг	2	Өмнөх үеийн бүтээсэн нийгэм-соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс болдог.
c	Нэгтгэн, зохицуулах чиг үүрэг	3	Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшсэнээр хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж байдаг.
d	Үйл ажиллагааны чиг үүрэг	4	Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь хэл юм.
e	Танин мэдэхүйн чиг үүрэг	5	Бие дааж бүгдийг мэдэх туршлагаас суралцдаг.

2.4 Хөдөлмөрийн зах зээлийн талаарх (a-e) ойлголтуудыг доорх 6 өгөгдлөөс тохируулан сонгож зөв харгалзуулна уу. /Нэг илүү өгөгдөл байгааг анхаарна уу/ /5 оноо/

- a. Эдийн засгийн идэвхтэй хүн ам
- b. Эдийн засгийн идэвхгүй хүн ам
- c. Ажилгүйдлийг бууруулах гадаад хүчин зүйлсийн арга
- d. Ажилгүйдлийг бууруулах эдийн засгийн арга
- e. Ажилгүйдлийг бууруулах захиргааны арга

1. Мэдээллийн сүлжээг бий болгох, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих
2. Улирлын үйл ажиллагаатай холбоотой үүссэн ажилгүйдэл
3. 16 хүртэлх насны хүүхэд, тэтгэврийн насны хүн ам, ажил эрж хайхаа больсон хүмүүс
4. Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
5. Хөдөлмөр эрхэлж байгаа болон бүртгэлтэй хөдөлмөр эрхлэхгүй байгаа иргэд /ажиллах хүч/
6. Гадаад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ИХ СУНГАА НИЙГМИЙН УХААН Хувилбар С

1. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Үйлдэгч нь урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар нь нийгмийн институтын юм.

A. Үүргийн зөрчил B. Ил чиг үүрэг C. Сөрөг чиг үүрэг
D. Далд чиг үүрэг E. Үүрэг

2. "Бидний үед сумын төвд зурагт гэж байсангүй тул Монголын радиогийн уран зохиол, яруу найргийн нэвтрүүлгийг чих тавин сонсдог байсан" гэсэн өгөгдөл нь нийгэмшилтийн аль агентад хамаарах вэ? /1 оноо/

A. Үе тэнгийнхэн B. Сургууль C. Хэвлэл мэдээлэл
D. Гэр бүл E. Ажлын байр

3. Эрэгтэй, эмэгтэй хүний биологийн буюу бие махбодийн ялгаа бүхий заяагдмал шинжийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

A. Жендэр B. Хүйс C. Насны нийтлэг
D. Угсаатны нийтлэг E. Тэгш бус байдал

4. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг гэнэ.

A. Хэл B. Үнэлэмж C. Мэдлэг D. Бэлгэ тэмдэг E. Хэм хэмжээ

5. Соёлыг ан агнуур, түүвэрлэгчдийн соёл, нүүдэлчдийн соёл, газар тариаланчдын соёл гэж ангилсан нь соёлын аль шалгуур үзүүлэлтэд нийцэж байна вэ? /1 оноо/

A. Суурь үнэлэмжээр нь B. Сонголт хийх боломжоор нь
C. Бүтээгч, хэрэглэгчээр нь D. Аж ахуй эрхлэлтээр нь E. Түвшингээр нь

6. Археологи, архитектур, гар урлал, үндэсний тоглоом, хувцас загвар, кино, дүрслэх урлаг, зар сурталчилгаа зэрэг нь соёлын аль ойлголтод хамаарах вэ? /1 оноо/

A. Соёлын үйлдвэрлэл B. Соёлын даяаршил C. Соёлын орон зай
D. Соёлын дархлаа E. Соёлын эрх чөлөө

7. Дараах байгууллагуудын аль нь соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэн явуулдаг вэ? /1 оноо/

A. Улаан загалмайн нийгэмлэг B. Эмнэлэг C. Цагдаагийн байгууллага
D. "Сүү" ХХК E. Номын сан

8. Нийгэмшилтийн талаарх ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

/3 оноо/

a	Сургууль	1	Итгэж байсан зүйлээсээ ухарч, хатуу ширүүн дэг журамд зохицон, өөрийгөө хүлээн авах дүр зургаа өөрчлөх гарцаагүй нөхцөлд ордог.
b	Дахин нийгэмшилт	2	Нийгэмшилтийн явцад хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг, нийгэмд харьяалуулан, тэдгээрийг илэрхийлэгч онцлог шинжийг тээгч нь болдог.
c	Адилсал	3	Тодорхой зорилго, түүнд хүрэх арга хэрэгсэл агуулга бүхий албан ёсны хөтөлбөрөөр хүүхдийн нийгэмшилтэд хувь нэмэр оруулахаар зорьж ажилладаг.

A. a2,b3,c1 B. a1,b2,c3 C. a2,b1,c3 D. a3,b1,c2 E. a1,b3,c2

9. Бусад хувьсагчийн өөрчлөлтөд нөлөөлж, шалтгаан нь болж буй хувьсагчийг үл хамаарах хувьсагч гэнэ. Жишээ нь: Ажилгүйдлийн түвшин өсөхөд ДНБ-ний хэмжээ буурдаг гэсэн өгөгдлөөс үл хамаарах хувьсагчийг олно уу. /1 оноо/

A. Ажил эрхлэлтийн түвшин B. ДНБ C. Ажилгүйдлийн түвшин
D. Үйлдвэрлэлийн хэмжээ E. ДНБ-ний хэмжээ

10. Багш Чимгээгийн 2019-2020 оны хичээлийн жилд ангийн сурагчдын төлөвшлийг судалсан ажиглалтын судалгааны үр дүнгээс харахад сурагчдын зан төлөв, идэвх оролцоо, харилцаа хандлага зэрэг нь мэдэгдэхүйц сайжирсан байгаа нь харагдаж байна. Судалгааны аргыг нэрлэнэ үү. /2 оноо/

A. Чанарын судалгаа B. Тоон судалгаа C. Бүлгийн ярилцлага
D. Туршилт E. Контент анализ

11. Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүний нэр хүндэд хамаарах ойлголтыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

A. Бусдад нөлөөлөх, дагуулах B. Шийдвэр гаргах, оролцох
C. Тусламж, тэтгэмж D. Олонд танигдсан байдал
E. Нөөцийг ашиглах, хуваарилахад хяналт тавих

12. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Олон нийтийн хөдөлгөөнд тулгуурласан, өргөн хүрээтэй шинэчлэл буюу засаглалын бүтэц, дэглэмийг өөрчлөхөд хүргэдэг, хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлсэн үйлдлийг гэнэ.

A. Нийгмийн өөрчлөлт B. Хувьсал C. Нийгмийн хөдөлгөөн
D. Шинэчлэл E. Хувьсгал


13. Германы социологич Ф.Тённисын нийгмийн хэв маягийн ангиллаас Гемайншафт /хөдөөний буюу уламжлалт/-ын онцлог шинжийг олно уу. /1 оноо/

A. Хөдөлмөрийн хуваарь энгийн B. Албан ёсны хууль чухал гэж үздэг
C. Хувийн ашиг сонирхлыг чухалчилдаг D. Хөдөлмөрийн хуваарь нарийссан
E. Төрийн үйл ажиллагаанд тулгуурладаг

14. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг зэрэг шинжүүдээр шууд ялгаагүй ч ямар нэг стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь ялгаатай байдалд хүргэхийг гэнэ.

A. Бурангуй үзэл B. Шууд алагчлал C. Институтийн алагчлал
D. Шууд бус алагчлал E. Алагчлал

15. Монголын түүхэн үеүд дэх нийгмийн давхраажилтыг харуулсан зураглалаас орхигдсон хэсгийг нөхөж бичнэ үү. /3 оноо/



A. 1. Юань улсын үе, 2. Хөх захтан
B. 1. XII-XIV зууны үе, 2. Талын язгууртнууд
C. 1. Юань улсын үе, 2. Номенклатурчид
D. 1. XII-XIV зууны үе, 2. Номенклатурчид
E. 1. Их Монгол Улсын үе, 2. Хамжлага ард

16. Нийгмийн нийтлэгүүдийг зөв харгалзуулна уу. /3 оноо/

a	Үндэс угсаа, хэл, соёл, түүх, зан заншил, газар нутаг, шашин зэргээр ижил төстэй нийгмийн нийтлэг	1	Насны нийтлэг
b	Хүний физиологийн хөгжлийн утгыг илэрхийлэхээс гадна нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлдог нийтлэг	2	Угсаатны нийтлэг
c	Зонхилогч биш шашныхан алагчлалд өртөн, улмаар олонхтой харьцуулахад харьцангуй дорой нөхцөлд аж төрөх нь бий	3	Шашны нийтлэг

A. a3,b2,c1 B. a2,b1,c3 C. a2,b3,c1 D. a3,b1,c2 E. a1,b2,c3

17. "Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм" гэж тодорхойлсон судлаачийг нэрлэнэ үү. /1 оноо/

A. Э.Кассирер B. А.Гидденс C. Р.Бенедикт D. Э.Тайлор E. К.Ясперс

18. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг холбогдох ойлголттой нь **буруу** илэрхийлсэн хариулт аль нь вэ? /2 оноо/

A. Хэл- дохио зангаа, хөдөлгөөн B. Мэдлэг- шинжлэх ухаан, хууль
C. Бэлгэ тэмдэг- төрийн дуулал, гэрлэн дохио D. Үнэлэмж- хүний эрх, шударга ёс
E. Хэм хэмжээ- дүрэм, журам, ёс заншил

19. Боловсролын институтийн хүрээнд багш хүн залуу хойч үеийнхний нийгэмшин хөгжихөд хувь нэмэр оруулахаар ажилладаг бол түүний орон байранд амьдрах хэрэгцээг хангахаар эдийн засгийн институтийн хүрээнд барилгачид ажиллана. Энэхүү жишээ нь дараах онолуудын алийг нь илэрхийлж байна вэ? /2 оноо/


A. Шалтгаант чанарын B. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн
C. Иргэншлийн D. Марксизмын E. Бүтэц чиг үүргийн

20. Монгол улсын хэмжээнд 1995 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр "Мөнх тэнгэрийн бичиг" уран бичлэгийн уралдаан зохион байгуулж ирсэн. Энэ нь олон улсын хэмжээн дэх соёлын бодлогын аль чиглэлд хамаарч байна вэ? /2 оноо/

A. Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог хангах
B. Үндэсний хэлний цэвэр ариун байдлыг сахин хамгаалах
C. Соёлын зорилго, хөгжлийн хандлагыг хүний хөгжилд чиглүүлэх
D. Үндэстэн, ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах
E. Соёлын харилцааг нээлттэй байлгах

21. Соёлын ойлголтуудын холбоо хамаарал, агуулгын багтаамжийг зөв илэрхийлсэн бүдүүвч аль нь вэ? /2 оноо/

a. соёл б. соёлын түүхэн маяг в. хүй нэгдлийн үеийн соёл



22. Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдолд хамааралтайг нь ялгана уу. /2 оноо/

1. Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгох
2. ДНБ-ны хэмжээг нэмэгдүүлж, амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг
3. Нийгмийн шударга ёсны зарчим, үнэ цэнийг бууруулдаг
4. Дэлхий нийтэд өөрсдийн брэндийг бий болгох

A. 1,2,4 B. 1,2,3,4 C. 1,3,4 D. 2,3,4 E. 1,2,3

23. Хувь хүн болон бүлгийн аж төрөх хэв маягаа сонгох нөхцөл, боломжийг үгүйсгэж, нийгмийн бусад гишүүдийн адилаар амьдрахыг шаардлага болгох нь соёлын эрх чөлөөг зөрчих хандлагын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Соёлын эрх чөлөө B. Хүний эрх, эрх чөлөө
C. Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах D. Тэгш эрх, шударга ёс
E. Амьдралын хэв маягийг үгүйсгэх

24. Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлын дадал хэвшлээсээ хавьгүй илүүд үзэж хүлээн зөвшөөрсөн сэтгэлгээний үр дүн нь соёлын харилцан үйлчлэлийн аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Соёлыг хуулбарлан дуурайх B. Соёлын солилцоо
C. Соёлын тулгалт D. Соёлын даяаршил E. Соёлын дархлаа

25. Соёлын даяаршлын **зөрөг** үр дагаваруудыг нэрлэнэ үү. /2 оноо/

1. Олон ургалч соёл дэлгэрч, янз бүрийн соёлыг мэдрэх боломж
2. Өөрийн соёлын уламжлалт хэв маягаас татгалзах
3. Өндөр хөгжилтэй орнуудад суралцах боломж
4. Ямар ч төрлийн мэдээллийг хоромхон зуурт авах, өгөх боломж

A. 1,2,3 B. 1,2,3,4 C. 1,2,4 D. 1,3,4 E. 2,3,4

26. Хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бэлэн байгаа төрөл бүрийн мэргэжилтэй ажиллах хүчний тоог юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Тэнцвэрт байдал B. Хөдөлмөрийн эрэлт
C. Хөдөлмөрийн нийлүүлэлт D. Ажиллах хүч E. Хөдөлмөрийн зах зээл

27. Ажиллах хүчний нийлүүлэлт нь эрэлтээс давсан /H>Э/ үед хөдөлмөрийн зах зээл дээр үүсэх үр дагавар аль нь вэ? /2 оноо/

- A. Ажиллах хүчний хомсдол үүснэ B. Ажиллах хүчний илүүдэл үүснэ
C. Тэнцвэрт байдал бий болно D. Хөдөлмөрийн бүтээмж буурна
E. Байгууллагын зардал өснө

28. Арилжааны банкны онцлог шинж аль нь вэ? /1 оноо/

- A. Валютын улсын нөөцийг эзэмших B. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
C. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх D. Зээл олгох, төлбөр тооцоо хийх
E. Арилжааны банкуудыг хянах

29. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Ажлын нэгж хугацаанд /нэг цаг, нэг өдөр, нэг сар/ зарцуулсан хөдөлмөрийнхөө төлөө ажилчны авч байгаа мөнгөн төлбөрийг гэнэ.

- A. Нэмэгдэл хөлс B. Бодит цалин C. Шагнал урамшуулал
D. Үндсэн цалин E. Нэрлэсэн цалин

30. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Хятад улсын хөрөнгө оруулалттай компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг аль улсын ДНБ, ҮНБ болохыг ялгана уу. /2 оноо/

- A. Хятад улсын ҮНБ, Монгол улсын ҮНБ
B. Монгол улсын ҮНБ, Хятад улсын ДНБ
C. Монгол улсын ДНБ, Хятад улсын ҮНБ
D. Хятад улсын ДНБ, Монгол улсын ДНБ
E. Монгол улсын бодит ҮЦБ, Хятад улсын ҮЦБ

31. ДНБ-ний орлого болон зардлыг ялгаж, тооцоолол хийнэ үү. /3 оноо/

№	ДНБ-ны бүтэц	Млрд төгрөгөөр
1	Төрийн зардал	80
2	Аж ахуйн нэгжийн зардал	120
3	Цалин	220
4	Зээлийн хүү	20
5	Шууд бус татвар	15
6	Өрх гэрийн хэрэглээний зардал	270
7	Түрээс	10
8	Гадаадын хэрэглэгчдийн зардал	50

- A. орлого- 520, зардал- 265 B. орлого- 265, зардал- 520
C. орлого- 250, зардал- 535 D. орлого- 535, зардал- 250
E. орлого- 255, зардал- 525

32. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Үнэт цаас гаргах, бүртгүүлэх, арилжих, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцааг гэнэ.

- A. Зах зээлийн харилцаа B. Бараа, үйлчилгээний зах зээл
C. Хөдөлмөрийн зах зээл D. Санхүүгийн зах зээл E. Эдийн засгийн харилцаа

33. Дараах өгөгдлүүдийг тохирох утгатай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /3 оноо/

1. Санхүүгийн зах зээл 2. Хөрөнгийн бирж 3. Үнэт цаас

- a. (_) Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах эрхийн бичиг
b. (_) Үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад шилжүүлэх зэрэг үнэт цаасны арилжаа явагдаж байдаг газар
c. (_) Үнэт цаас гаргах, бүртгүүлэх, арилжих, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцаа
A. a3,b2,c1 B. a3,b1,c2 C. a1,b2,c3 D. a2,b3,c1 E. a1,b3,c2

34. Гүйлгээнд их хэмжээний мөнгө бий болж, харин түүгээр худалдан авах барааны тоо хэмжээ бага байгаагаас барааны үнэ өсөхөд хүргэдэг нь инфляци үүсэх шалтгааны аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Хэвийн инфляци
D. Эрэлтийн инфляци
- B. Зардлын инфляци
E. Гипер инфляци
- C. Мөлхөө инфляци

35. Ажилгүйдлийн түвшин 2 хувь өссөн үед бий болох эдийн засгийн үр дагаварыг Оуэкену хуулиар тооцоолон гаргана уу. /2 оноо/

- A. ДНБ 2%-иар буурна
D. ДНБ 2,5%-иар өснө
- B. ДНБ 2,5%-иар буурна
E. ДНБ 5%-иар буурна
- C. ДНБ 5%-иар өснө

36. Зөвлөлдөх санал асуулгад оролцож хуулийн төсөлд саналаа өгөх нь иргэдийн оролцооны аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. ИТХ болон ИНХ-д оролцох
B. Төлөөллөөр дамжуулан оролцох
C. Улс төрийн сонгуульд оролцож саналаа өгөх
D. Хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох
E. Сонирхлын бүлгээр дамжуулж оролцох

37. Дараах ойлголтуудаас иргэдийн **нийцтэй** оролцоог ялгана уу. /2 оноо/

1. Өлсгөлөн зарлах
2. Эсэргүүцлийн жагсаал цуглаан
3. Сонгуульд оролцож саналаа өгөх
4. Захидал бичих
5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан үзэл бодлоо илэрхийлэх
6. Авлига өгөх

- A. 1,2,4,5
B. 3,4,5,6
C. 3,4,5
D. 3,5,6
E. 1,3,5,6

38. "Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл явдал юм" гэж хэлсэн эрдэмтэн аль нь вэ? /1 оноо/

- A. А.Линкольн
B. Н.Макиавелли
C. Р.Даль
D. Ж.Локк
E. Д.Истон

39. Иргэд сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтнаар дамжуулалгүй нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийн биеэр оролцдог, өөрөөр хэлбэл олон түмэн өөрөө өөрийгөө удирдах нь ардчиллын аль хэлбэр вэ? /1 оноо/

- A. Ардчилал
D. Элитийн ардчилал
- B. Төлөөллийн ардчилал
E. Олон ургалч ардчилал
- C. Шууд ардчилал

40. Монгол улсын Үндсэн хуульд "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж заасан нь ардчиллын аль үнэт зүйлстэй нийцэж байна вэ? /1 оноо/

- A. Хуулийн засаглал
C. Иргэдийн улс төрийн оролцоо
- B. Хүний эрх, эрх чөлөө
D. Олон намын тогтолцоо
- E. Тэгш эрх

41. Иргэд Засгийн газарт санал өгөх боломжуудыг нэрлэхдээ **буруу** зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Нэг цонхны үйлчилгээнд хандаж саналаа өгөх
B. Иргэд Засгийн газарт хандаж саналаа захидлаар илэрхийлэх
C. Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд саналаа өгөх
D. Засгийн газрын хуралд оролцож саналаа илэрхийлэх
E. Засгийн газрын мэдээллийн вэб сайтад хандаж саналаа өгөх

42. Эрх зүйн актуудын төрөл болон төрийн байгууллагыг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /2 оноо/

1. Тогтоол
2. Тушаал
3. Зарлиг

- a. () Монгол Улсын Ерөнхий сайд
b. () Монгол Улсын Засгийн газар
c. () Монгол Улсын Ерөнхийлөгч

- A. a1,b2,c3
B. a2,b3,c1
C. a3,b1,c2
D. a3,b2,c1
E. a2,b1,c3

43. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/
Хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурлаас батлан гаргаж, нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоон, биелэлтийг нь төрийн албадлагын хүчээр хангаж байдаг бичмэл эрх зүйн хэм хэмжээг гэнэ.

- A. Тушаал
B. Хуульчилсан акт
C. Зарлиг
D. Хууль
E. Захирамж

44. Аав, ээж нь гэрээсээ хол, илүү цагаар ажилладаг тул гурван хүүхэд нь гэртээ хоол унд муутай, даарсны улмаас өвчин тусжээ. Энэ тохиолдолд Хүүхдийн эрхийн Конвенцийн дараах заалтуудаас аль нь зөрчигдөж байна вэ? /2 оноо/

- A. Эцэг эх нь хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэхгүй байх;
B. Хүүхдийн захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн халдаж болохгүй;
C. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;
D. Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, сүсэглэх эрхийг хүндэтгэх;
E. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх;

45. Монгол улсын иргэний үндсэн үүрэг аль нь вэ? /1 оноо/

- A. Эрүүл мэндээ хамгаалах
C. Хуулиар ногдуулсан албан татвар төлөх
E. Байгаль орчноо хамгаалах
- B. Хөдөлмөрлөх
D. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх

46. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг" гэж заасан нь хүний эрхийн аль суурь зарчим бэ? /1 оноо/

- | | |
|---------------------------------|------------------------------|
| A. Түгээмэл, салшгүй байх | B. Хуваагдашгүй байх |
| C. Хүн үнэ цэн, нэр төртэй байх | D. Харилцан хамааралтай байх |
| E. Хариуцлага тооцох | |

47. Шүүхийн шийдвэргүйгээр улсын хуулиас гадуур хүнийг гэм буруутайд тооцож үл болох зарчмыг анхлан тунхагласан түүхэн баримт бичиг аль нь вэ? /1 оноо/

- | | | |
|--------------------|------------------------------------|------------|
| A. Үндсэн хууль | B. Хүний эрхийн түгээмэл тунхаглал | |
| C. Сирусын бортого | D. Эрх чөлөөний харти | E. Конвенц |

48. Хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдээс **илүүц** зүйл оруулсан бол аль нь вэ? /2 оноо/

- A. Хөдөлмөрийн нөхцөл
B. Ажлын байрны буюу албан тушаалын нэр
C. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг
D. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ
E. Нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал

49. Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн харилцааг нийгмийн хамгааллын эрх зүйн аль харилцаагаар зохицуулдаг вэ? /1 оноо/

- | | | |
|-----------------------|--------------------------------|--------------------|
| A. Нийгмийн даатгал | B. Нийгмийн халамж | C. Иргэний эрх зүй |
| D. Захиргааны эрх зүй | E. Нийгмийн хамгааллын эрх зүй | |

50. Иргэн - Захиргааны байгууллагатай харилцахдаа эдлэх эрхийг олно уу. /1 оноо/

- | | |
|---------------------------------|--------------------------------------|
| A. Гомдлыг шийдвэрлэх үүрэг | B. Захиргааны шийдвэр, үйл ажиллагаа |
| C. Өргөдлийг шийдвэрлэх үүрэг | D. Мэдэх эрх |
| E. Хүссэн мэдээллийг өгөх үүрэг | |

51. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал нь Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчмын аль хэлбэр вэ? /1 оноо/

- | | | |
|-------------------------|-------------------------------|---------------------|
| A. Тэнцвэртэй | B. Олон тулгууртай | |
| C. Прагматик /идэвхтэй/ | D. Үндэсний эрх ашигт нийцсэн | E. Хамтын ажиллагаа |

52. Олон улсын харилцааны үндсэн оролцогчийг олно уу. /1 оноо/

- | | | |
|---------------------|---------------------------------------|--------------------|
| A. Билл Гейтс | B. Унгар улс | C. Олон улсын шүүх |
| D. Тоёото корпораци | E. Дэлхийн зөн олон улсын байгууллага | |

53. Монгол улсын дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааны түвшинг дээшлүүлэх нь Монгол улсын гадаад харилцааны аль бодлогын зорилго вэ? /1 оноо/

- | | | |
|-------------------|------------------|-----------|
| A. Шинжлэх ухааны | B. Эдийн засгийн | C. Соёлын |
| D. Хүмүүнлэгийн | E. Улс төрийн | |

54. Олон улсын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр үүсгэн байгуулагдаагүй, ашгийн бус, хоёроос дээш улсаас хандив авч үйл ажиллагаа явуулдаг олон улсын харилцааны үлс бус оролцогч аль нь вэ? /1 оноо/

- | | |
|--|--------------------------------------|
| A. Нөлөө бүхий хувь хүн | B. Үндэстэн дамнасан корпораци |
| C. Олон улсын байгууллага | D. Олон улсын төрийн бус байгууллага |
| E. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ | |

55. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү. /1 оноо/ Монгол улсын хоёр хөрштэйгээ харилцахдаа баримталдаг зарчмуудаас орхигдсон хэсгийг олно уу.

- Тэнцвэртэй
- Стратегийн түншлэлийн
-
- Олон тулгуурт
- Хамтын ажиллагааны

- | | | |
|-----------------|----------------|------------------|
| A. Сайн хөршийн | B. Улс төрийн | C. Эдийн засгийн |
| D. Соёлын | E. Боловсролын | |

56. Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго аль нь вэ? /1 оноо/

- A. Шинжлэх ухаан, технологийн чадавхийг нэмэгдүүлэх
B. Түүх соёлын үнэт зүйлээ сэргээн хамгаалах
C. Дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх
D. Эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах
E. Гадаад сурталчилгааг сайжруулах

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1 Олон улсын харилцааны улс оролцогчдын талаарх ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Де-факто	1	Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг.
b	Де-юре	2	Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.
c	Их гүрэн	3	Тухайн улсыг бүрэн бүс хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу "бараг хууль ёсны" гэсэн утгатай.
d	Дунд улс	4	Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг.
e	Бага улс	5	Тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу "хууль ёсны" гэсэн утгатай.

2.2 Бүдүүвчид ардчиллын үнэт зүйлсийг (a-e) харуулжээ. Эдгээрийг тохирох утгатай нь (1-5) зөв тохируулна уу. /5 оноо/



1. Хүний эрх нь нийгмийн харилцаанд оролцох боломжийн хэм хэмжээг илэрхийлсэн ойлголт.
2. Иргэд төрийн хэрэгт оролцох нь тэдний эрх төдийгүй иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг юм.
3. Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэгтэй.
4. Иргэн бүр хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээдэг.
5. Ардчилсан нийгэмд иргэдийг боловсролтой болоход анхаардаг бөгөөд боловсролтой иргэд нь ардчиллыг хөгжүүлэх нэг гол хөшүүрэг гэж үздэг.

2.3 Соёлын элемент дэх зарим ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

/5 оноо/

a	Домог	1	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанарууд
b	Шашин	2	Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг багтаасан ойлголт
c	Шинжлэх ухаан	3	Ямар нэг онолын байгууламж биш, харин мэдрэмж, ид шид, дүр, төсөөлөлд тулгуурласан сэтгэлгээ
d	Үнэлэмж	4	Хүмүүсийн сүсэг бишрэлийн эрэлт хэрэгцээгээр бий болсон оюуны хэлбэр
e	Хэм хэмжээ	5	Аливаа зүйлийг үнэн эсэхийг шалган тодорхойлох тусгах арга, аргачлал, зарчимд тулгуурладаг

2.4 Хөдөлмөрийн зах зээлийн талаарх (a-e) ойлголтуудыг доорх 6 өгөгдлөөс тохируулан сонгож зөв харгалзуулна уу. /Нэг илүү өгөгдөл байгааг анхаарна уу/ /5 оноо/

- a. Эдийн засгийн идэвхтэй хүн ам
- b. Эдийн засгийн идэвхгүй хүн ам
- c. Ажилгүйдлийг бууруулах гадаад хүчин зүйлсийн арга
- d. Ажилгүйдлийг бууруулах эдийн засгийн арга
- e. Ажилгүйдлийг бууруулах захиргааны арга

1. Мэдээллийн сүлжээг бий болгох, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих
2. Улирлын үйл ажиллагаатай холбоотой үүссэн ажилгүйдэл
3. 16 хүртэлх насны хүүхэд, тэтгэврийн насны хүн ам, ажил эрж хайхаа больсон хүмүүс
4. Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
5. Хөдөлмөр эрхэлж байгаа болон бүртгэлтэй хөдөлмөр эрхлэхгүй байгаа иргэд /ажиллах хүч/
6. Гадаад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах

№	В ХУВИЛБАР		С ХУВИЛБАР	
	Зөв хариу	Оноо	Зөв хариу	Оноо
1	D	1	D	1
2	C	1	C	1
3	B	1	B	1
4	D	1	B	1
5	A	1	D	1
6	E	1	A	1
7	D	1	E	1
8	C	3	D	3
9	B	1	C	1
10	D	2	A	2
11	E	1	D	1
12	A	1	E	1
13	D	1	A	1
14	C	1	D	1
15	B	3	C	3
16	D	3	B	3
17	E	1	D	1
18	A	2	B	2
19	D	2	E	2
20	C	2	B	2
21	B	2	E	2
22	C	2	A	2
23	D	1	E	1
24	E	1	A	1
25	D	2	D	2
26	C	1	C	1
27	B	2	B	2
28	C	1	D	1

29	B	1	E	1
30	D	2	C	2
31	E	3	B	3
32	A	1	D	1
33	D	3	A	3
34	C	1	D	1
35	B	2	E	2
36	D	1	D	1
37	E	2	C	2
38	A	1	E	1
39	D	1	C	1
40	C	1	E	1
41	B	1	D	1
42	D	2	E	2
43	E	1	D	1
44	A	2	A	2
45	D	1	C	1
46	C	1	B	1
47	B	1	D	1
48	D	2	E	2
49	E	1	A	1
50	A	1	D	1
51	D	1	C	1
52	C	1	B	1
53	D	1	E	1
54	E	1	D	1
55	A	1	A	1
56	D	1	D	1

2.1	a-5	1	a-3	1
	b-1	1	b-5	1
	c-4	1	c-1	1
	d-2	1	d-2	1
	e-3	1	e-4	1
2.2	a-4	1	a-4	1
	b-5	1	b-5	1
	c-1	1	c-1	1
	d-2	1	d-2	1
	e-3	1	e-3	1
2.3	a-4	1	a-3	1
	b-3	1	b-4	1
	c-1	1	c-5	1
	d-2	1	d-1	1
	e-5	1	e-2	1
2.4	a-5	1	a-5	1
	b-3	1	b-3	1
	c-6	1	c-6	1
	d-4	1	d-4	1
	e-1	1	e-1	1